

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2020 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
4 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН  
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Хэлэлцсэн асуудал</b>	<b>Хуудасны дугаар</b>
<b>1.</b>	<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-23
<b>2.</b>	<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	
	1. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 02 дугаар дүгнэлт	30-41
	2. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай асуудал	41-51
	3. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 10 гишүүн 2020.04.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	51-80
	4. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 7 гишүүн 2020.04.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	80-96
	5. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Засгийн газраас 2020.04.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	96-109
	6. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	109-135
	7. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 14 гишүүн 2020.04.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	135-159

## ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

***Тав.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Засгийн газраас 2020.04.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Хууль, эрх зүйн газрын ахлах референт Ч.Дондогмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Болормаа, Б.Хатантуул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ “Их хуралдай” танхимаас, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас тус тус танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нар хариулж, тайлбар хийв./*Танхим тус бүрийн нэр өгсөн дарааллыг сөөлжүүлэн асуулт асуух зөвшөөрөл өгсөн болно/*

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн М.Билэгт, Д.Оюунхорол нар үг хэлэв./*Танхим тус бүрийн нэр өгсөн дарааллыг сөөлжүүлэн үг хэлэх зөвшөөрөл өгсөн болно/*

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6<sup>1</sup>.15-д заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав. Танхим тус бүрээс ирсэн санал хураалтын дүнэ нэгтгэн танилцуулав.*

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 14

Бүгд: 47

70.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.*

## **ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

***Тав.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Засгийн газраас 2020.04.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэх асуудалдаа орно. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна.

Л.Оюун-Эрдэнэ сайдыг индэрт урьж байна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэн баталсан билээ.

2020 оны 02 дугаар тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийг баталж, уг хуваарьт тусгагдсан хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасны дагуу Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд боловсруулсан бөгөөд товчлон танилцуулбал дараах асуудлуудыг тусгалаа.

Нэгдүгээрт, сонгуулийн үр дүнгээр аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй тохиолдолд улс төрийн нам, эвсэл заавал олонхыг бүрдүүлж Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх шаардлагыг Засгийн газрын эмхлэн байгуулах үндэслэл, журмын хэсэгт.

Хоёр. Ерөнхий сайд Засгийн газрын бүтцийн болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх. Зөвшилцөж чадаагүй тохиолдолд өөрөө өргөн мэдүүлэх зохицуулалтыг;

Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдийн 4-өөс илүүгүй нь Улсын Их Хурлын гишүүн байж болох тухай зохицуулалтыг;

Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөх бөгөөд тангараг өргөх журмыг Улсын Их Хурал тогтоохоор;

Ерөнхий сайд Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулсны үндсэн дээр Засгийн газрын гишүүнийг томилж, чөлөөлөх, огцруулах асуудлыг;

Ерөнхий сайдыг огцруулах, Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцрох тухай зохицуулалтыг;

Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсэж холбогдох тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр Улсын Их Хурал Ерөнхий сайдад итгэл хүлээлгэхгүй байгаа тухай шийдвэр гаргавал Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцрох зохицуулалтыг;

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Засгийн газрын эмхлэн байгуулах журам, Ерөнхий сайдыг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах журам, зохицуулалт өөрчлөгдсөн тул тус хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол

Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулсан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Засгийн газрын тухай хууль Монгол Улсын Үндсэн хуультай нийцэж Засгийн газрын тогтвортой ажиллах эрх зүйн үндэслэл хангагдана гэж үзэж байна.

Хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Намсрайн Амарзаяа “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас танилцуулна. Н.Амарзаяа гишүүнийг танилцуулгаа хийхийг урьж байна.

**Н.Амарзаяа:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хууль, тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн болно.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд 4 зүйлийн холбогдох хэсэг, заалтыг өөрчлөн найруулж, 2 хэсэг, 1 заалтыг шинээр нэмж, 5 зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулж, 4 хэсгийг хүчингүй болгохоор төслийг боловсруулжээ.

Төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан Монгол Улсын Их Хурлаас баталсан 2020 оны 02 дугаар тогтоолд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийг боловсруулахад баримтлах чиглэл болгосон асуудлуудыг бүрэн тусгасан эсэх талаар асуулт асууж, санал хэлсэн болно.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2020 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслийг хэлэлцээд үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлнэ үү.

Б.Баттөмөр гишүүн, Дондогдоржийн Эрдэнэбат гишүүн. Өөр гишүүн байна уу? Дондогдоржийн Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

**Д.Эрдэнэбат:** Баярлалаа дарга аа. Ирцээ бүрдүүлэхгүй бол хүн байхгүй байна шүү дээ.

Тэгээд ийм чухал хууль хэлэлцэх гэж байдаг. Засгийн газар өөрийнхөө энэ хуулийн өөрчлөлтийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд зохицуулаад оруулж ирж байдаг. Тэгээд ийм хариуцлагатай хуралдаан дээр нь гишүүд байхгүй. Тэгээд асууж байгаа ч гишүүд алга. Сонирхож байгаа ч хүн алга. Ийм байдалтай байж болохгүй шүү дээ.

Бид Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж байх үед Ардчилсан намын оруулсан зарчмын 3 саналын 1 нь энэ л дээ. Ерөнхий сайд кабинетаа өөрөө байгуулах энэ бол энэ Үндсэн хуулийн гол заалтууд. Энэ улс орны төрийн байгууламж яаж өөрчлөгдөж байгаа юм бэ гэдгийг ард иргэдэд мэдрүүлэх ийм л ганц заалт орсон.

3 саналын харамсалтай нь Ерөнхийлөгчийг парламентаас сонгох, сонгуулийг холимог тогтолцоогоор явуулах гэдэг хоёр заалт нь унасан байгаа юм. Тэгээд Үндсэн хуульд заахдаа Үндсэн хуулийг бид 2020 оны 5 сарын 25-аас эхэлж мөрдөнө гэж. Тэгээд л мөрдсүгэй гэж заасан.

Энэ Засгийн газрын хуулийг Ерөнхий сайдыг яг Их Хурлын өөрийнх нь шууд эрх мэдлийн хамгийн түрүүнд шийдвэрлэдэг ийм институт учраас үүнийг бусад дагалдах хуультай адилхнаар авч үзэж болохгүй л дээ.

Тэгэхээр Үндсэн хуулийн заалт 5 сарын 25-наас хэрэгжих ёстой бол Засгийн газрын бүрэлдэхүүн Үндсэн хуулийн дагуу 5 сарын 25-аас өөрчлөгдөх нь зүй ёсны гэж хараад байгаа юм. Ялангуяа энэ давхар дээлтэй 16 сайд нь Үндсэн хуульд заагдсан 4 сайд нь Улсын Их Хурлын гишүүн байна. Бусад нь Улсын Их Хурлын гишүүн байхгүй гэдэг заалт зайлшгүй мөрдөгдөх ёстой. Үүнийг дагалдах бусад хуулиар органик хуулиуд шиг ингэж авч үзэж дараа нь хийнэ гэсэн боломж хуулийн хүрээнд байхгүй гэж би харж байгаа.

Одоо өнөөдрийн оруулж ирж байгаа энэ Засгийн газрын өргөн барьсан хууль дотор хоёр нюанс байгаа.

Нэгдүгээрт, Ерөнхий сайд нь Ерөнхийлөгчтэй зөвшилцөхдөө сонин. Нэг хоног гээд заачихсан. Үндсэн хуульд шал өөр заалт байдаг. Тэгээд энэ яагаад зөрчилдөж орж ирсэн юм бэ гэдэг дээр би тодруулга авмаар байна.

Хоёрдугаарт, энэ хуулийг дагалдуулаад Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах заалтууд орж ирсэн.

Яг өнөөдөр үүнтэй давхцуулаад Улсын Их Хурлын тухай хуульд сая анхны хэлэлцүүлгийг дуусчихлаа. Дэгийн тухай хууль хэлэлцэх эсэх нь орж ирлээ.

Тэгэхээр Л.Оюун-Эрдэнэ сайд энэ дээр надад нэг хариулт өгмөөр байна. Энэ хуулиудтай одоо энэ орж ирж байгаа өргөн баригдсан Их Хурлын хуулиудтай Засгийн газрын өргөн барьсан энэ дэгийн тухай хууль Улсын Их Хурлын тухай хууль хоёр зарчмын ялгаатай зүйл юу байна вэ? Энэ дээр нэгдүгээрт хариулт өгөөч гэж.

Ер нь дэгийн тухай хуулийг хэн хариуцаж байгаа юм. С.Бямбацогт билүү. Энэ хууль өргөн барьсан хүмүүс, ажлын хэсэг энэ дээр хамт хэлэлцээд явах арга юу байдаг юм. Тийм ээ. Тэгээд нэг л юм гарахгүй бол нэг хуулийг хоёр талд нь хоёр өөр утгаар хэлэлцээд. Дараа нь баахан хууль хоорондын зөрчил үүсчих вий гэсэн болгоомжлол байгаад байна.

Тэгэхээр энэ тал дээр надад нэг ийм тодорхой хариулт өгөөч ээ гэж.

**Г.Занданшатар:** Хууль санаачлагч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн сайд Л.Оюун-Эрдэнэ асуултад хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Баярлалаа. Д.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурлын дэгийн хууль болон бусад хуультай холбоотой асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга хариулах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Миний хувьд илүү өмнөх асуулттай нь холбоотой асуудлыг хариулъя.

Ер нь бид судалж үзсэн. 1992, 2000 он. Өмнө нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсон нөхцөл байдлыг судалж үзсэн. Нөхцөл байдлууд дээр ч гэсэн ерөнхийдөө дагах хууль хүчин төгөлдөр болоод хэрэгжээд зохицуулаад явж байгаа ийм зохицуулалтууд бас байна.

Тэгэхлээр энэ дээр нэг их тийм хууль зөрчих асуудал байхгүй юм гэж тайлбарлаж байгаа. Энэ дээр бид Төрийн байгуулалтын байнгын хороо болон бусад Хууль зүйн байнгын хороо зэрэг манай хуулийн эрх зүйн баримт бичигтэй холбоотой дүгнэлт гаргадаг байгууллагуудтай харилцан зөвшилцсөн байж байгаа.



Тэгэхлээр энэ бол сонгуулийн дүн гарсан анхдугаар чуулганаас хэрэгжиж эхлэхээр зохицуулах нь зүйтэй гэдэг дүгнэлтэд хүрсэн гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Яах вэ, мэдээж энэ бол нөгөө улс төрийн бас нэг сэдэв болж маргаан мэтгэлцээн өрнөж байгааг бид ажиглаж байгаа. Шаардлагатай бол үүнийг шийддэг буюу Үндсэн хуулийн цэцтэй холбоотой асуудал дээр маргаан хагалагдах нь зүйтэй байх гэсэн ийм байр суурьтай байгаа юм гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт явж байх үед миний хувьд ч гэсэн. Д.Эрдэнэбат гишүүн санаж байгаа байх. Ардчилсан намын 3 саналаас 2-ыг нь үнэхээр дэмжиж байсан. Гэхдээ Үндсэн хууль бол өөрөө бас өндөр босготой явдаг учраас энэ бол ингээд дэмжигдээгүй байсан ийм зүйл байгаа. Үүнийг цаашдаа бид анхаарч ярилцах нь зүйтэй байх.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол аль нэг намын ч юм уу, одоо реформ гэх юм уу, шинэчлэл, эрх зүйн баримт бичиг биш гэж бодож байгаа. Энэ дээр Монгол Улсын Ерөнхийлөгч, парламентад суудалтай байгаа намын бүлгүүд, манай Улсын Их Хурлын гишүүд бүгд л оролцож бид энэ зүйлийг хийсэн. Тэгээд нийлж баталчхаад тэгээд сонгууль болохоос хэдхэн хоногийн өмнө хамтын бүтээлээ бид ингээд зүгээр улс төрийн зорилгоор шүүмжлэх нь бол бас тийм зохимжтой биш байх гэсэн зүгээр тийм бодолтой байж байгаа.

Цаашдаа олон олон дагах хуулиуд хийгдэнэ. Шүүхийн тухай хуулиас авхуулаад, Нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль гээд л. Тэгж байж одоо яг энэ Үндсэн хуулийн үзэл санаа цаашдаа хэрэгжиж, шинэ 30 жилийн суурийг тавих байх гэсэн ийм итгэл үнэмшилтэйгээр явж байгаа.

Монгол Улсын Засгийн газрын хувьд ерөнхийдөө бид Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, нийцэх гэдэг утгаараа аль болохоор нэг тийм илүү дутуу олон нэмэлт заалтыг оруулахгүй байх зарчмыг ажлын хэсэг дээр бас барьж ажилласан байж байгаа. Ингээд өнөөдөр хэлэлцэх эсэх. Ямар ч өөрчлөлт оруулах нь ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүд, намын бүлэг, зөвлөлд бүрэн эрх нь байж байгаа гэдэг ийм хариулт өгөх нь зүйтэй байх гэж бодож байна.

Бусад тэр дэгтэй холбоотой асуудал дээр С.Бямбацогт гишүүн дэлгэрэнгүй хариулах нь зүйтэй байх гэж бодож байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Сандагийн Бямбацогт гишүүн асуултад хариулна.

**С.Бямбацогт:** Тэгэхээр Д.Эрдэнэбат чинь чухал асуудал хөндөж байна. Өнгөрсөн онд бид Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж баталсан.

Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2000 оноос хойш л үндсэндээ Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах ёстой. Дордуулсан 7 өөрчлөлтийг засах ёстой гэж ярьж ирсэн. 2010 оноос хойш Үндсэн хуулийн нэмэлт,

өөрчлөлтийг батлах гэж одоо бас хичээж үе үеийн парламент ажиллаж байсан. Өмнөх парламентын үед ч гэсэн бас Д.Эрдэнэбат гишүүн бид санаачлаад, гарын үсэг зураад явж байсан ийм түүхтэй.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийж чадсан нь энэ удаагийн парламентын нэлээд том чухал ололт амжилт. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулж нийтдээ 46 хуульд шинэчилсэн найруулга болон нэмэлт, өөрчлөлт шүү дээ. Дээрээс нь анхдагч 2 шинэ хууль батлах Улсын Их Хурлын 02 дугаар тогтоол 1 сард бид баталсан.

Энэ хүрээндээ хаврын чуулганаар зайлшгүй хэлэлцэн батлах ёстой хуулиуд Улсын Их Хурлын тухай хууль, Засгийн газрын тухай хууль хоёр бол зайлшгүй. Яагаад гэвэл одоо 6 сард сонгууль болно. Сонгуулийн дараа шинээр Улсын Их Хурал, шинээр Засгийн газар бүрдэнэ. Үүнд шинэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд үйл ажиллагаа явуулах ёстой. Энэ хүрээндээ Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль, “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Аудитын хууль гэх мэтийн хуулиудыг бид батлахаар хэлэлцэж байгаа. Маш яаралтай шахуу ажиллаж байгаа. Улсын Их Хурал.

Ингэхдээ энэ цаг үед бид Улсын Их Хурлын хууль, Засгийн газрын хууль, энэ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль. Энэ хуулиудын хоорондын нийцэл, зохицол, хийдэл давхардал үүсгэхгүй байх тал дээр илүү анхаарч ажиллах ёстой.

Улсын Их Хурлын тухай хууль, дэгийн тухай хууль дээр Засгийн газрын гишүүнийг томилохтой холбоотой Засгийн газрын тухай хууль дээр орж ирээгүй. Дэгийн тухай хуулиар зохицуулна гээд үлдээчихсэн байгаа. Тэгвэл Засгийн газрын тухай хуульдаа ч Засгийн газрын гишүүнийг ямар тангараг өргөх юм. Улсын Их Хуралд тангараг өргөх ёстой шүү дээ. Засгийн газрын гишүүн. Ингэхдээ ямархуу хэлбэрээр өргөх юм, ямар тангараг байх юм гэдэг нь зайлшгүй цаашид ярих шаардлага байна.

Цаашдаа давхар дээлтэй сайд нар нь ямархуу байдлаар ажилтай явах юм. Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайд нь огцруулах, чөлөөлөх, томилохдоо ямар зарчим баримтлах юм гэх мэт зүйл, заалтуудыг суулгах. Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурал, Засгийн газрын харилцааг хэрхэн яаж зохицуулах вэ. Үүнийг чуулганы хуралдааны болон Байнгын хорооны хуралдааны дэгдээ яаж тусгах вэ гэдэг асуудлыг зайлшгүй нэг суурь нөхцөл дээрээс тавьж үзэж ярьж байгаа.

Тийм болохоор өнөөдөр ингээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Улсын Их Хурлын тухай болон Засгийн газрын тухай хууль, чуулганы хуралдааны дэгийн тухай хууль яригдаж байгаа нь яг одоо нэг нөхцөл дээрээс. Тэгэхгүй урьд нь салангид салангид байдлаар ярихаар хоорондоо зохицолдохгүй байх, хууль хоорондоо хийдэл, зөрчил үүсэх ийм асуудлууд байдаг байсан бол аль болох энэ хийдэл, зөрчил гаргахгүй байх тал дээр

Улсын Их Хурлын Тамгын газар, Төрийн байгуулалтын байнгын хороо анхаарч ажиллаж байгаа.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хууль гэхэд нийтдээ 100 гаруй удаа нэмэлт, өөрчлөлт орсон байдаг. Батлагдсанаасаа хойш. Засгийн газрын тухай хууль ч гэсэн бас 1993 онд батлагдсан. Үүнээс хойш 69 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байгаа юм. Тийм болохоор одоо бас энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсан хүрээндээ бид энэ хуулиудаа бас нэг мөр цэгцлээд, хоорондын уялдаа холбоодыг нь хангаад, зохицлыг хангах тал дээр илүү анхаарч ажиллах нь энэ удаагийн парламент, энэ удаагийн чуулган, бид бүгдийн хуралдаж байгаа цаг хугацаанд нэлээд ач холбогдол өгч анхаарч ажиллах зайлшгүй шаардлага үүссэн. Үүн дээр ч бас Байнгын хороо анхаарч ажиллаж байгаа гэдгийг хэлье.

**Г.Занданшатар:** Чуулганы танхимуудын ирцийг шалгасан мэдээ ирүүлж байна. Ирц хангалттай бүрдсэн байна.

Нэг зүйлийг тодруулаад хэлчихье. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдөх журмын тухай хуулийг бид баталсан. Энэ хууль бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй нэгэн адил хүчинтэй байна гэж заасан. Ийм ч учраас нийт гишүүдийн дөрөвний гурав буюу 57-гоос дээш ирцтэйгээр энэ дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталсан.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулиудыг шинэчлэн батлах хүртэлх хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг баримтална. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгахаар заасан.

Энэ хуваарийн дагуу энэ хаврын чуулганаар хэлэлцэж байна. Мөн энэ хуульд ийм практик бол 1990 оны Үндсэн хуулийн нэмэлтийг батлахад, 1992 оны Үндсэн хуулийн шинэ Үндсэн хуулийг батлаад хавсралт дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталсан.

Бусад дэлхийн улсууд ч гэсэн Үндсэн хуулийн шилжилтийн тухай хууль гэдэг хуулийг баталдаг. Энэ дэлхий нийтийн жишиг манай Монгол Улсын практикт нийцүүлж ингэж баталсан.

Энэ талаар Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны 2 академич, үндсэндээ 3 академич байдаг. Энэ талаар тодруулга саяхан хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлснийг Та бүхэн үзсэн байх.

Ж.Амарсанаа академич, С.Нарангэрэл академич, Н.Лүндэндорж гуай академич нар Үндсэн хуулийн цэцийн дарга, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн зөвлөлийн дарга зэрэг ажил хийж байсан.

Энэ шинэ Үндсэн хуулийг батлах үйл явцад гар бие оролцсон энэ хүмүүс энэ талаар онолын хувьд болон практикт ямарваа нэгэн зөрчил байхгүй гэдгийг нотолсон.

Энэ талаар маргаан байхгүй гэдгийг энд онцлон тэмдэглэж байна.

Одоо Б.Баттөмөр гишүүн “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас асуулт асууна.

**Б.Баттөмөр:** Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурал баталсан хуваарь графикийнхаа дагуу оруулж байна. Үдээс урагш Их Хурлын тухай хууль, дэгийн тухай хууль гээд ярьцгаасан.

Энэ Засгийн газрын хуульд Үндсэн хуульд орж байгаа өөрчлөлттэй холбогдуулаад нэлээн өөрчлөлтүүд орохоор хуулийн төсөлд орж ирж байна. Шинэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан гүйцэтгэх эрх мэдлийн тогтвортой, хариуцлагатай байдлыг хангахтай холбоотой асуудал орж ирж байна. Санал нэг байгаа.

Ерөнхий сайдыг томилох хүний саналыг Ерөнхийлөгч 5 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах ёстой. Энэ хуульчлагдаад явж байна.

Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхийлөгчтэй 7 хоногийн дотор зөвшилцөж чадахгүй бол Улсын Их Хуралд шууд танилцуулна. Ерөнхий сайд Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Засгийн газрын гишүүдийг өөрөө томилж, чөлөөлөх, огцруулах бүрэн эрхтэй байхаар Үндсэн хуулийн заалт энэ Засгийн газрын хуулийн нэмэлт, өөрчлөлтөд бас явж байна.

Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй саналаар Ерөнхий сайдыг огцруулах. Тэгээд Ерөнхий сайдыг томилох саналаа хамт оруулж ирж байгаа. Энэ бол бас их зүйтэй. Хуучин нэг хүнийг огцруулчихдаг. Дараа нь шинэ Ерөнхий сайдаа томилж чаддаггүй их удаж байсан тохиолдлууд Монголын парламентын, Засгийн газрын түүхэнд байдаг.

Ерөнхий сайд төсвийн бодлогын тодорхой асуудлаар өөрт итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж, 10 хоногийн дотор шийднэ. Гишүүдийн олонхын санаа шийдвэр, эсвэл тогтоолыг баталсан бол Ерөнхий сайд итгэл үзүүлж тухай асуудлыг дэмжсэнд тооцно. Тогтоолыг батлахгүй бол огцорсонд тооцох гээд их олон зүйл, заалтууд энд явж байна.

Ерөнхий сайд Засгийн газрын 4-өөс илүүгүй гишүүн Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болохоор тогтоож, Үндсэн хуулийн заалт бол энд явж байна. Энэ бол тэр дордуулсан 7 заалтыг сайжруулах чиглэлээр хийгдэж байгаа ажил гэж ингэж ойлгож байна.

Сая С.Бямбацог дарга яриандаа хэллээ. Энэ Засгийн газрын тухай хууль 1993 онд батлагдсан байдаг юм. Одоо энэ үндсэндээ 27 жил. Манай энэ ардчилсан нийгэм, чөлөөт зах зээлтэй бараг адилхан. 27 жил болчихож.

Тэгээд 69 удаа өөрчлөлт орсон гэж байгаа юм. Үндсэн хуулиа бид чинь 2019 оны 11 сарын 14-ний өдөр шиг санаж байна. Баталсан. Энэ хооронд чинь 5 сар илүү, бараг 6 сар шахуу хугацаа өнгөрсөн байна. Энэ Засгийн газрын хуулиа шинэчилж найруулж болдоггүй юм уу? Энэ чинь тал талаас нь янз бүрийн юм оруулсаар байгаад олон дахин нөхсөн дугуй шиг болсон байна шүү дээ.

Энэ 5 сарын хугацаанд ийм боломж байсан шиг санагдаад байх юм. Засгийн газрын тухай хуулийн тэр 7 дугаар зүйлд байж байгаа хуулийн биелэлтийг зохион байгуулах гэдэг дээр зайлшгүй өөрчлөлт оруулах шаардлага байгаа. 8 дугаар зүйл дээр байгаа тэр эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн бодлого боловсруулах гээд. Боловсруулж хэрэгжүүлэх гээд. Энэ дээр зайлшгүй шаардлага одоо байгаа юм.

Монгол Улсын яамдын зохион байгуулалт чиг үүргийн 6, чиглэлийн 7 гээд. Энэ дээр юу гэж хэлэх гэж байна гэхээр Монгол Улсын 30 жилийн түүхэнд Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт гэдэг юм огт алга болсон. Худалдааны бодлого гэж байдаггүй. Дэд сайд нь сайдаа орлодоггүй. Тэгээд сайдаа оролгүй дэд сайд байгаад байх хэрэгтэй ч юм уу, хэрэггүй ч юм уу.

Гэх мэтийн олон асуудлууд байна. Үүнийг яагаад шинэчилж болоогүй юм бэ? Ололт амжилт бол өнгөрсөн 27 жилд байна. Алдаа дутагдал тэрнээсээ илүү байна. Тэрний зонхилох хэсэг нь Засгийн газартай холбоотой. Тийм учраас үүнийг.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Б.Баттөмөр гишүүнд нэмэлт 1 минут.

**Б.Баттөмөр:** Бид ардчилал, зах зээлийн нийгэмд орсон 30 жилийн хугацаанд ололт амжилт бол байгаа.

Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 17.5 дахин өссөн л гэж байгаа. Тэгэхээр тооцооны асуудлууд бол бий. Гэтэл өнөөдөр ядуурал бодит байдал дээр гурван хүний нэг нь ядууралтай холбогдсон байна шүү дээ. Одоо ядуурчихсан байгаа.

Бодит судалгаанаас харахаар өнөөдрийн ажилгүйдлийн түвшин үнэхээр хүнд. Ер нь бодит байдал их хүнд байна шүү дээ. Ижил гараанаас гарсан тэр орнуудтай харьцуулахад бидний хөгжлийн олон үзүүлэлтээр хоцорч явж байгаа.

Тэгээд энэ бүхнийг яагаад өнөөдөр ингэж яриад байна гэхээр Монгол Улсын алдаа дутагдлын нэг хэсэг нь Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотой.

**Г.Занданшатар:** Л.Оюун-Эрдэнэ сайд асуултад хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Б.Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Б.Баттөмөр гишүүнтэй санал нэг байгаа. Тийм учраас Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын 30 жилийн шилжилтийн цаг хугацааг үнэлж

дүгнэе. Ижил гараанаас орсон орнуудаас суурь хөгжлийн үзүүлэлт дээр ямар байна. Дараагийн 30 жилийг бүхэлд нь төсөөлье. Өмнө нь салангид байгаад ирсэн 523 бодлогын баримт бичгүүдээ нэгтгэе. Хэрвээ бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхгүй байвал түүн дээр хуулийн хариуцлага тооцдог механизмыг нь гаргая. Зөвхөн Сангийн яам одоо жишээлбэл хөгжлийн бодлого тодорхойлоод яваад байх биш, эдийн засгийн төлөвлөлттэй холбоотой, үндэсний хөгжилтэй холбоотой асуудлыг зохицуулдаг төрийн захиргааны төв байгууллага байгуулах нь зүйтэй юм.

Энэ утгаараа Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хөгжлийн бодлого урт хугацаанд тогтвортой байна. Мөн урт хугацааны хөгжлийн бодлогод суурилж залгамж чанартайгаар улс орны хөгжлийн асуудал шийдвэрлэгдэнэ гэдэг ийм агуулга бүхий заалтууд орсон.

Өнөөдөр Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр хамт хэлэлцэгдэж байгаа. Энэ хөтөлбөр батлагдсаны дараа нэлээдгүй томоохон төрийн захиргааны хувьд Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотой олон асуудлууд дээр өөрчлөлтүүд гарах байх гэж бодож байгаа юм.

Тэр томоохон өөрчлөлттэй холбоотой асуудлуудыг сонгууль дөхсөн энэ үед бас Засгийн газрын хуулийг бүхэлд нь өөрчилж оруулж ирэх нь бас цаг үеэ олоогүй асуудал юм гэдэг байдлаар бидний хувьд зөвлөсөн. Тийм учраас нэн яаралтай байгаа суурь зарчимтай холбоотой Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудлууд дээр хариулт өгөхүйц 9 зүйл дээр гол төвлөрч заалтуудыг хуульд нийцүүлэх байдлаар хийгдсэн байж байгаа.

Цаашдаа Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль батлагдаад, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын хөтөлбөр батлагдаад ингээд явах үед Үндсэн хуулийн зарчимд нийцэж, хэрвээ Засгийн газар ямар нэгэн байдлаар Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийг зөрчиж, эсвэл урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалаа зөрчөөд л Үндсэн хуулийн шүүх дээр асуудал шийдэгддэг болох хэмжээний ийм эрх зүйн шинэчлэл рүү бид сая бас хийгдэж чадсан.

Тэгэхээр цаашдаа дараагийн шинэ 30 жил бол илүү хөгжлийн бодлого тогтвортой, төрийн үйл ажиллагаа залгамж чанартай, олон салангид бодлого биш, нэгдмэл бодлогын суурь концепцтой урагшлах суурь нөхцөл байдал тавигдана гэдэгт итгэлтэй байгаа.

Тэгээд энэ зүйл дээр манай Б.Баттөмөр гишүүн нэлээдгүй олон удаа яг энэ суурь асуудлыг хөндөж ярьж байгаад бидний хувьд санал нэгтэй байдаг. Ирэх долоо хоногоос ч гэсэн үүнтэй холбоотой олон асуудлууд яригдахаар Улсын Их Хурал дээр хүлээгдэж байгаа. Тэр үеэр илүү дэлгэрэнгүй хариулаад, харилцан ярилцаад, зөвшилцөөд явах боломжтой гэж үзэж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо үг хэлэх гишүүн байна уу? Дэмжсэн дэмжээгүй 3 хүртэлх гишүүн үг хэлж болно. Энэ төслийн хэлэлцэх эсэхийг. Алга байна. Д.Оюунхорол гишүүн. М.Билэгт гишүүн, Д.Оюунхорол гишүүнээр тасаллаа. М.Билэгт гишүүн үг хэлнэ.

**М.Билэгт:** Энэ 2016 оны Улсын Их Хурлын сонгуулиар Монголын ард түмэн Монгол Ардын намд 65 суудлыг өгсний гол нэг үр дүн нь бол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт өөрчлөлтийг оруулж чадсан нь юм. Энэ бол ард түмний хүсэн хүлээж байсан юм.

2000 оноос эхлээд дордохын 7 гэсэн заалтыг л байнга энэ 20 шахам жил ярьж байсан. Тэгээд энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг дордохын долоогоосоо өгсүүлээд гол гол заалтуудыг бас хэдий бүрэн төгс хэмжээнд мэдээж байхгүй ч гэлээ гэсэн том ахицыг гаргасан нь чухал өөрчлөлтийг хийсэн.

Үүний нэг бол энэ Засгийн газрыг Ерөнхий сайд өөрөө Засгийн газрын бүрэлдэхүүнээ томилдог, саналаараа оруулж ирдэг болсон нь, өөрөөр хэлбэл Ерөнхий сайд Засгийн газрын бүрэлдэхүүнээ ямар хэмжээнд авч явж чадах вэ гэдэг хүнээ сонгож сонгох энэ боломжийг олгосон нь маш чухал юм.

Мөн нөгөөтээгүүр Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлын гишүүдээс Улсын Их Хурлын 4 хүртэлх гишүүн Засгийн газрын гишүүн байна гэж оруулсан нь өмнө нь ард түмний яг хүсэн хүлээж байсан ийм заалтууд болсон юм. Тийм учраас энэ хуулийн төслийг дэмжиж байгаа гэдгээ хэлье.

**Г.Занданшатар:** Дуламсүрэнгийн Оюунхорол гишүүн үг хэлнэ.

**Д.Оюунхорол:** Энэ хуулийг зарчмын хувьд дэмжиж байна.

Ер нь Монгол Улс сүүлийн 20 гаруй жил Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг хийж, тэр тусмаа улс орны хөгжилд саад садаа болоод байгаа засаглалын эрх мэдлийг тэнцвэртэй хуваарилах, гүйцэтгэх засаглалын ажлыг хийх боломжийг хангаж өгөх асуудлыг их олон жил ярьсан. Өөрөөр хэлбэл Монгол Улсын парламентад Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх эрх олгогдсоноор үнэхээр Засгийн газрын үйл ажиллагааг хэвийн явуулахад саад учруулдаг. Засгийн газар үйл ажиллагаагаа хэвийн явуулахад боломж өгөхгүй байна гэж үзэж байсан.

Засаглалын эрх мэдэл тэнцвэргүй байгаа тухай их ярьсан. Тэгээд энэ удаагийн Үндсэн хуулийн өөрчлөлтөөр Монгол Улсын Ерөнхий сайд кабинетаа өөрөө байгуулж, Засгийн газрынхаа гишүүдийг өөрөө томилдог, чөлөөлдөг, хариуцлага тооцдог, Улсын Их Хурлын өмнө ганцаараа хариуцлагаа хүлээдэг байх дэлхий нийтийн жишиг рүүгээ явсан.

Энэ бол нэгдүгээрт гүйцэтгэх засаглалын ажил хийх боломж, чадвар, хариуцлагыг илүү дээшлүүлсэн. Нөгөө талаас парламентын эрх мэдэл тодорхой хэмжээгээр хязгаарлагдаж Улсын Их Хурлын гишүүд бол хууль тогтоох байгууллагынхаа ажилд илүү хариуцлагатай хандах ийм нөхцөл боломж бүрдэж байгаа.

Тийм учраас Засаглалын эрх мэдлийн тэнцвэргүй, алдагдсан байдал энэ удаагийн өөрчлөлтөөр бүрэн шийдэгдэх боломжтой болсон. Нөгөө талаас сонгуулийн дүнгээр аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй тохиолдолд улс төрийн нам, эвсэл заавал олонхыг бүрдүүлж Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх

шаардлагыг Засгийн газрыг эмхлэн байгуулах үндэслэл, журам, хэсэгт нь оруулж өгсөн.

Ерөнхий сайд, Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх заалт орж өгч байгаа. Ингэснээрээ засаглалын бүх эрх мэдлийг харьцангуй тэнцвэртэйгээр хувааж асуудлыг шийдвэрлэх боломж бололцоонууд бүрдсэн гэж үзэж байгаа.

Тэгээд ер нь гүйцэтгэх засаглалыг ажлаа хийх, хариуцлагаа тооцуулж дүгнүүлэх бүрэн боломж хангагдсан. Тэгэхээр Ерөнхий сайдын эрх мэдэл илүү өргөн, илүү хариуцлагатай, илүү парламентын өмнө дангаараа хариуцлагаа үүрэх том боломж нээгдсэн. Тийм учраас энэ удаагийн хууль бол олон жил Монголын төрийн тогтолцоонд байгаа эрх мэдлийн хуваарилалтын зөрчлийг арилгаж чадсан өөрчлөлт болсон. Энэ удаагийн энэ хуулиар үүнийг бас хөлсөнд нь суулгасан хууль орж ирсэн. Тийм учраас энэ хуулийг дэмжиж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Одоо Байнгын хорооны саналаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Дөрөв. Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

“Их хуралдай” танхим. Д.Тогтохсүрэн гишүүн.

**Д.Тогтохсүрэн:** 12 гишүүн санал хураалтад оролцож, 7 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** О.Батнасан гишүүн. “Эзэн Чингис хаан” танхим.

**О.Батнасан:** 9 гишүүн оролцож, 5 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** Б.Баттөмөр гишүүн. “Жанжин Д.Сүхбаатар” танхим.

**Б.Баттөмөр:** 11-ээс 8 байна.

**Г.Занданшатар:** Д.Ганболд гишүүн.



**Д.Ганболд:** “Үндсэн хууль” танхим 7-гоос 5.

**Г.Занданшатар:** М.Билэгт гишүүн. “Их засаг” танхим.

**М.Билэгт:** “Их засаг” танхим 8 гишүүн санал өгснөөс 8 гишүүн дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 47 гишүүн оролцож, 35 гишүүн дэмжиж, 74.5 хувийн саналаар хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ.

Хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.